


**Нэг. Иргэд, байгууллагаас цагдаагийн байгууллага,
албан тушаалтанд гаргасан санал, өргөдөл, гомдлын
шийдвэрлэлтийн талаар**

Төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн албан тушаалтанд 2016 оны эхний 9 сард иргэд, байгууллагаас 7026 санал, өргөдөл, гомдол ирүүлснийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 217 нэгж буюу 3.1 хувиар буурчээ.

Нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдлын 188 буюу 2.7 хувь нь санал, 6655 буюу 94.7 хувь нь өргөдөл, 183 буюу 2.6 хувь нь гомдол байна.


Санал, өргөдөл, гомдлыг
утгаар нь авч үзвэл: 1050 буюу 14.9 хувь нь ажилд орох, суралцахыг хүссэн, 243 буюу 3.5 хувь нь ажилд дахин орохыг хүссэн, 975 буюу 13.9 хувь нь ажил өөрчлөх, шилжихийг хүссэн, 1607 буюу 22.9 хувь нь захиргааны чөлөө хүссэн, 303 буюу 4.3 хувь нь тэтгэвэр, тэтгэмж, орон сууц хүссэн, 2848 буюу 40.5 хувь нь бусад өргөдөл гомдол байна.



Нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдлын 6942 буюу 98.8 хувийг шийдвэрлэж, 84 буюу 1.2 хувь нь ажиллагаанд





байна.




Хоёр. Цагдаагийн ерөнхий газрын удирдлагад иргэд, байгууллагаас ирүүлсэн санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн талаар

2016 оны эхний 9 сард Цагдаагийн ерөнхий газрын удирдлагуудад иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас 550 өргөдөл, гомдол ирүүлснийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 174 нэгж буюу 31.6 хувиар буурчээ.

Нийт хүлээн авсан өргөдөл, гомдлын 1 буюу 0.2 хувь нь санал, 25 буюу 4.5 хувь нь гомдол, 524 буюу 95.3 хувь нь өргөдөл байна.





Иргэд, байгууллагаас цагдаагийн ерөнхий газрын удирдлагад ирүүлсэн өргөдөл, гомдлыг үтгээр нь авч үзвэл: 54 буюу 9.8 хувь нь ажилд орох суралцахыг хүссэн, 55 буюу 10.0 хувь нь ажилд дахин орохыг хүссэн, 73 буюу 13.3 хувь нь ажил өөрчлөх, шилжихийг хүссэн, 21 буюу 3.8 хувь нь захиргааны чөлөө хүссэн, 48 буюу 8.7 хувь нь тэтгэвэр, тэтгэмж, орон сууц хүссэн, 299 буюу 54.4 хувь нь бусад өргөдөл, гомдол байна.



Гурав. Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 11-11 төвд ирсэн өргөдөл, гомдол, шүүмжлэл, санал хүсэлтийн талаар


2016 оны эхний 9 сард иргэдээс Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын “11-11” төвд цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаатай холбоотой 518 санал хүсэлт, гомдол, талархал, шүүмжлэл, өргөдөл ирүүлсний 183 буюу 35.3 хувь нь санал хүсэлт, 236 буюу 45.5 хувь нь гомдол, 77 буюу 14.9 хувь нь талархал, 19 буюу 3.7 хувь нь шүүмжлэл, 3 буюу 0.6 хувь нь өргөдөл байна.



Иргэдээс ирүүлсэн санал хүсэлт, гомдол, талархал, шүүмжлэл, өргөдлийн 444 буюу 85.7 хувийг шийдвэрлэж, 74 буюу 14.3 хувь нь ажиллагаанд байна.

Иргэдэд хариу хүргүүлсэн байдлыг чанараар нь авч үзвэл 163 буюу 36.7 хувийг 5 хоногийн дотор, 281 буюу 63.3 хувийг 5-аас дээш хоногт шийдвэрлэжээ.

Дөрөв. Иргэд, байгууллагаас цагдаагийн алба хаагчтай холбоотой ирүүлсэн өргөдөл, гомдлын талаар



2016 оны эхний 9 сард иргэд, байгууллагаас цагдаагийн алба хаагчтай холбоотой 1239 өргөдөл, гомдол хүлээн авч шалгасныг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 29 нэгж буюу 2.4 хувиар өсч, 1387 алба хаагч холбогдсоны 1148 буюу 82.8 хувь нь офицер, 231 буюу 16.7 хувь нь ахлагч, 9 буюу 0.6 хувь нь энгийн ажилтан байна. Нийт өргөдөл гомдлын 1201 буюу 96.9 хувийг барагдуулж, 38 буюу 3.1 хувь нь ажиллагаанд байна.